

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2019 ОНЫ НАЙМДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 08 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 07 дугаар сарын 26-аас 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 99 орны 1796 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 10, нэг удаагийн орох 1597, хоёр удаагийн орох 18, олон удаагийн орох 22, нэг удаагийн гарах-орох 33, олон удаагийн гарах-орох 6, нэг удаагийн дамжин өнгөрөх 110, түр ирэгчийн бүртгэл 281, хасалт 298, оршин суух зөвшөөрлийн хасалт 44 байна.

Үүнээс гадна визийн хуудас 3 ширхэгийг хүчингүй болгосон ба Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон визийг шинээр 13 орны 27 гадаадын иргэнд олгосон ба оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон виз 3 орны 6 гадаадын иргэн байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд тус газрын даргын баталсан 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 10/10 дугаар удирдамжийн дагуу Төв аймгийн Баянчандмань суманд үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй 1 орны 34 гадаадын иргэнийг шалгасан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар Хяналт шалгалтын газрын даргад танилцуулан, энэ оны 8 дугаар сарын 19-ний өдөр 10/03 дугаартай албан шаардлагыг дээрх аж ахуйн нэгжид хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мөн “ISM” системээр давхардсан тоогоор 165 орны 65017 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба зөрчил илрээгүй.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-аас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан 2019 оны 8 дугаар сард нийт 14 орны 19 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгасан бөгөөд зөрчил илрээгүй байна. Үүнээс гадна 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 22-ны өдрийн хоорондох тайланг гаргаж, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэлтийн талаар:

Тайлант хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 23 орны 104 гадаадын иргэнд 8,650,000 төгрөг, 8 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 8/ 6,060,000 төгрөг, нийт 14,710,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд тус газраас 1 орны 1 гадаадын иргэнийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 37 дугаар зүйлд заасны дагуу ГИХГ-ын даргын 2019 оны А/280 дугаар тушаалаар энэ оны 7 дугаар сарын 30-ны өдөр албадан гаргасан ба төвөөс 3 орны 5 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад орох визгүй нийт 4 орны 17 гадаадын иргэн, 1 харьяалалгүй иргэн, нийт 18 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан байна. Харин гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 5 орны 15 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.

Шүүх, ШШГЕГ, прокурорын байгууллагын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 79 гадаадын иргэн, 1 харьяалалгүй иргэн, нийт 80 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.

Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 4 орны 65 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 14 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 3 орны 5 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 2 тушаал /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 1, хүний нөөцтэй холбоотой 1/ батлан гаргаж биелэлтийг тооцон ажилласан ба 2019 оны наймдугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 30 ажил хийж гүйцэтгэхээр тусгасан бөгөөд биелэлт 100 хувьтай гарлаа.

Түүнчлэн тус газраас 2019 оны есдүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлээ. Үүнд:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж энэ оны 8 дугаар сарын 27-ны өдөр, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж 26-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст;

- 2015, 2016, 2017, 2018, 2019 онд ажил хүлээлцэх акт үйлдсэн албан хаагчдын талаарх судалгааг гаргаж 8 дугаар сарын 12-ны өдөр, өргөдөл, гомдлын мэдээг гаргаж 23-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт.

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байгаа ба хэмжилтээр дулаан 23-25С, чийг 50-60RH байна. Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газрын даргын батлан гаргасан тушаал, ирсэн, явсан албан бичиг, сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг скайнердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.

Бичиг хэрэгт 10 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 4 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 10 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард иргэнээс 1 гомдол ирснийг бүртгэж, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж холбогдох албан хаагчид хүргүүлж, шийдвэрлүүлсэн бөгөөд гомдлын хариуг хуульд заасан хугацаанд өгч ажилласан. Тус газарт энэ сард өргөдөл ирээгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 26 албан хаагч, ээлжийн амралттай 4, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байгаа ба сахилгын талонд арга хэмжээ авахуулсан албан хаагч байхгүй болно. Байгууллагын даргын 2019 оны Б/198 дугаар тушаалаар тус газарт сүлжээний инженер томилогдон ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн цахим програмд тус газрын нийт албан хаагчийн 7 дугаар сард авсан нэмэгдэл, шагналын талаарх мэдээллийг оруулсан.

Нийслэлийн Онцгой байдлын газрын Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр сургалт зохион байгуулж тус төвийн сургагч багш х/ч М.Цогтбаяр, а/д Д.Солонго нар 10 албан хаагчдад мэдээлэл хүргэж, дадлага сургуулилт хийлгэв.





2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 402,069,700 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 219,823,388 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 24,360,704 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 11,935,253 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.08.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 402,069,700 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 255,406,337 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2019.08.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 53,126,032 төгрөгөөр тооцоо нийлэв.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас 98, визийн хуудас 1500 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Хүү торгууль өссөн дүнгээр 73,330,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 404,238,410 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 1,477,871 төгрөг, байрны түрээс 21,600,250 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.

Бараа материалд 7,917,280 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 10,905,700 төгрөгийн зарцуулалт гаргаж тайлагнасан байна.

Тус газрын 26 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд явагчийн өрөөний веб камерийн тохиргоог шинэчлэн нууцлалыг хангаж нэвтрэх эрх болон нууц үг хийж тус газрын даргын утастай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 11 компьютерийн хэвийн ажиллагааг шалгаж шаардлага хангахгүй байгаа 2 компьютерийг порматлан хэвийн ажиллагаанд оруулсан.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2019 оны 7 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээ, 8 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суух болон төрийн байгууллагын урилгаар ирсэн, Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнийг зохих байгууллагад Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор урьж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлэх талаар гарын авлага бэлтгэн зорчигчдод тарааж байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын Агаарын тээврийг хялбаршуулах болон аюулгүй байдлын хорооны 2019 оны 02 дугаар хурал энэ оны 8 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан ба тус газрын 1 албан хаагч оролцсон. Уг хурлаар “Нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн ачаалал хэтэрсэн үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний төсөл, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрт орсон нэмэлт өөрчлөлт, зуны нислэгээр эрс нэмэгдээд байгаа нисэх буудлаар дамжин өнгөрөх, шилжин суух зорчигчийн урсгал зохицуулалтыг сайжруулах талаар хэлэлцсэн байна.



Дөрөв. Байгууллагын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний талаар

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийг Хөшгийн хөндий дэх шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгээс ирүүлсэн “Улаанбаатар хотын Олон улсын

шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө"-нд тусгах саналгүй талаар Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Ашиглалтын өмнөх захиргааны албаны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зохицуулагч инженер Н.Сүнжидмаад цахимаар мэдэгдэв.

Тав. Бусад

Байгууллагын дэд даргын 2019 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 02/1447 дугаар “Зөрчил, дутагдлыг арилгаж ажил сайжруулах тухай” шалгалтын зөвлөмжийн дагуу зохих ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус газрын нийт албан хаагчдын хурлыг 2019 оны 8 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж АЗБХГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч үүрэг даалгавар өгөв.

Төвөөс энэ оны 7 дугаар сарын 29-ний өдөр АЗБХГ-ын захиргааны байранд цагийн бүртгэлийн төхөөрөмжийг байршуулсан.